



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ” СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар A/10.


Бор-Өндөр сум

Гүйцэтгэлийн үнэлгээний баг байгуулж,
үнэлгээнд хамрагдах багш нарын нэрсийг
батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 35 дугаар зүйлийн 35.3, 35.4 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Журам батлах тухай” A/115 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Удирдамж батлах тухай” A/38 дугаар тушаал, Хэнтий аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” A/22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн багшийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээг зохион байгуулах үүрэг бүхий гүйцэтгэлийн үнэлгээний багийг нэгдүгээр, гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах багш нарын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Багшийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу чанартай зохион байгуулж ажиллахыг үнэлгээний баг (М.Нармандах), гүйцэтгэлийн үнэлгээнд амжилттай хамрагдахыг багш нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ 
Ч.АМАРЖАРГАЛ

